



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 10 дахь заалтыг тус тус үндэслэн төрийн өөрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах зорилгоор ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 53 дугаар тогтоолын 1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.2.Төрийн өөрийн өмчийн талбай болон бусад эд хөрөнгийг түрээслүүлэхэд түрээслүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар комисс байгуулна. Комисст Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2 хүртэл төлөөллийг оруулж болно.”

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 53 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тогтоолыг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА